


Процессын өөрчлөлтийн үр дагавар олон жилийн дараа гэнэт илэрч болзошгүй. 2023 оны 01 сар



Зураг 1: Урсгалын бүдүүвч – Хэсэг хэмжээний амин Хаягдлын цех рүү алдагдсан

2011 оны 06 сарын 02-ны өдөр Англи улсын нэгэн боловсруулах үйлдвэрт танк дэлбэрсний улмаас дөрвөн хүн амиа алдаж, нэг хүн хүнд бэртжээ. Хүчтэй дэлбэрэлтийн нөлөөгөөр танкны 5 тонн жинтэй ган дээвэр 55 метрийн зайд шидэгдэж, өндөр шатамхай шинж бүхий бутаны хий алдагдсан. Танкны доторх шатамхай орчинд гал ноцсон нь дэлбэрэлтийн шалтгаан болжээ. Дэлбэрэлтийн шалтгаан нь савны доторх шатамхай уур үүссэнээс болсон байна. Гал асаах магадлалтай эх үүсвэр нь статик цахилгаан байсан.

Осол тохиолдохоос 10 гаруй жилийн өмнө тус байгууламжийн амин боловсруулах цехэд өөрчлөлт хийгдэж байжээ. Ингэхдээ хаягдал нүүрсустөрөгчийн хоолойд хадгалагдаж байсан аминийг сэргээх буюу дахин ашиглахын тулд хаягдал бодисыг аюулгүй зайлуулах зориулалттай системийн чиглэлийг өөрчилж, амин боловсруулах цехийн Танк 302 руу буцааж урсгасан байна. Байгууламж тэрхүү үйлдлийг баримтжуулаагүй. Уг өөрчлөлтийн улмаас Т302 танк дотор амины шингэний дээр шатамхай шинж бүхий шингэн нүүрсустөрөгч аажмаар хуримтлагдсан бөгөөд энэ нь операторуудын хувьд сайн мэддэг аюул аж.

Осол тохиолдох үед танкийг засвар үйлчилгээнд бэлдэх зорилгоор цэвэрлэж байсан ба танкны зайлуулах хоолой болон нүүрсустөрөгчийг хэрхэн зайлуулах тухай ямар нэгэн мэдээлэл, зааварчилгаа ашиглаагүй байна. Бохирын машин Танк 302-ын дээрх нээлхийгээр шингэн шавхаж байх үед дэлбэрэлт үүссэн. Бохирын машинд цахилгаан дамжуулдаггүй шланг холбогдсон байсан нь статик цэнэг үүсгэсэн ба энэ нь гал ноцоох эх үүсвэр болсон байх магадлалтай.

<https://www.hse.gov.uk/comah/chevron-pembroke-report-2020.pdf>

## Та мэдэх үү?

- Боловсруулалтын үйл ажиллагааны бүх журамд Өөрчлөлтийн Менежментийн (МОС) процесс багтдаг.
- Үйлдвэрлэлийн салбарын томоохон ослуудын олон нь процессын өөрчлөлтийн улмаас үүссэн төлөвлөгдөөгүй үр дагавартай холбоотой байдаг.
- Тоног төхөөрөмж, химийн бодис, ашиглалтын болон засвар үйлчилгээний журам зэрэгт орсон өөрчлөлт бүрийг шалгаж, зөвшөөрөл олгох ёстой.

## Та юу хийж болох вэ?

- Урсгалын чиглэл болон бусад процесст (даралт, температур, найрлага гэх мэт) өөрчлөлт орсон үед зураг төсөл эсвэл холбогдох дүрэм журамд тусгагдалгүй орхигдохоос болгоомжил.
- Үр нөлөө нь аажмаар нэмэгддэг өөрчлөлтөөс сэрэмжил. Хянагдаагүй өөрчлөлтийн үр нөлөө нь нууцлаг байж болох бөгөөд удаан хугацаанд, магадгүй хэдэн жилийн туршид ч, анзаарагдахгүй өнгөрөх эрсдэлтэй.
- Аливаа өөрчлөлт хийхдээ холбогдох дүрэм журмыг мөрд. Зарим компанийн хяналтын арга хэмжээнүүд нь өөрчлөлтийн төрлүүдээс хамааран янз бүр байдаг.
- Тухайн өөрчлөлттэй холбоотойгоор дүрэм журмыг шинэчлэх шаардлагатай байж болно. Дүрэм журмыг сайтар уншиж, ажлыг аюулгүй гүйцэтгэх талаар бүрэн ойлгохоос нааш үйлдэл бүү хий.

**Процесст орсон өөрчлөлт бүрийг хянах ёстой.**